

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Д/д	Хийх ажлын үндсэн чиглэл		Биелэлт
I	Дотоод үйл ажиллагааны чиглэлээр		
1.1.	МТҮП-ын ашиглалтыг сайжруулах	Силикон хаус төслийн барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, барилгыг хүлээн авах, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах	Силикон хаус төслийн нээлт 5-р сарын 8-д болсон бөгөөд энэхүү арга хэмжээний зохион байгуулалт болон барилгын гүйцэтгэлд хяналт тавин хүлээн авах ажлыг хэсгийг тус тус гарган зохион байгуулалтыг ханган ажиллаа. Нээлтийн үйл ажиллагаанд 200 гаруй зочид төлөөлөгчид оролцсон бол Эрдэм шинжилгээний бага хуралд 70 гаруй хүн оролцож Эмбеддэд системийн талаар илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлээ. / Үйл ажиллагааны тайланг нэгтгэн гаргасан./ 100%
		Төслийн хүрээнд хийгдсэн барилгын ажил бүрэн дуусаагүй бөгөөд 1,2-р давхрын гардены засвар, Лифт суурилуулах, Хяналтын камерын нэгдсэн систем суурилуулах, Галын аюулгүйн систем суурилуулах, Гадны үүдний засвар г.м томоохон ажлуудаас гадна засаж сэлбэх ажил хийгдэхгүй байгаа. Силикон Хаус төслийн нээлтээс хойш засвар хийгдсэн хэсгүүдийн цонхы гадна амалгаа хийгдсэн. Байгууллагын зүгээс гүйцэтгэгч компанид удаа дараа шаардлага хүргүүлсээр байгаа. Үйл ажиллагааны хувьд сургалтын төв, компьютер вишн лабортори хэвийн ажиллагаа явуулж байна. Эмбэдэд системийн лаб болон номын сангийн хувьд холбогдох бүргэлийн програм ашиглалтанд орсон байна. 80%	
		МТ-ийн инкубаторын орчинг тохижуулах зорилгоор уран зургийн уралдаан зохион байгуулсан бөгөөд нийт 9-н зураачийн 10-н уран бүтээл ирснээс энхний 3-н байрыг шалгаруулав. 1-р байр Д.Дашдоржын /Хувцас бурхан бие чөтгөр/ 2-р байр Б.Золбоо /Харилцаа/ 3-р байр Д.Уянга /IT-Төг амьдрал/. 10 уран бүтээлээс 1 уран бүтээлийг буцаан олгож одоогийн байдлаар 9 зурагтай байна. /100%/	
		Хоёрдугаар давхарын засварын үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын хүрээнд Монгол тамга ТӨҮГ-ийг нүүлгэх талаар дээд байгууллагт хүсэлт гарган Ерөнхий сайдын захирамжын дагуу шийдвэрлэв. /100%/	
		Засвар, өргөтгөл болон бусад	Байгууллагын 4-р давхарын дээврийн хар цаасыг сэргээн засварлах ажлыг ТБОНӨХБАҮХАТ Хуулийн дагуу харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулж “Сувдан Өргөө Констракшн” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, сонгон шалгаруулж, ажил хүлээж авах ажлын хэсгийг ахлан, гэрээний хугацаанд акт үйлдэн хүлээн авсан. /100%/ Сантехник, дулааны засвар үйлчилгээ ажлын хүрээнд зуны улиралд хийх засварын ажлын хүрээнд узелийн өрөөнд агааржуулалтын систем угсрах, халаалтын босоо шугамын засвар, гадна дулааны шугамын нягтын шахалт хийх, ажилчдын цайны газрын ус, дулааныг холбох зэрэг ажлыг гүйцэтгэв. Мөн бохирын болон бусад гэмтлийг цаг тухай бүр засч, нийт 70 гаруй засвар үйлчилгээний ажлыг гүйцэтгэв. /100%/

		<p>Байгууллагын ажилчдад зориулсан цайны газар байгуулах санаачлага гарган, төслийн баримт бичгийг /20 гаруй хуудас/ боловсруулан удирдлагаас дэмжлэг авч, өөрсдийн нөөц бололцоог ашиглан засвар, тохижилтын ажлыг 10-р сард гүйцэтгэн 11-р сараас үйл ажиллагааг явуулж эхлээд байна. /100%/</p>
		<p>Гаражийн дээврийг засварлах ажлыг Монголиан инженеринг буйлдинг ХХК тай ажил гүйцэтгэх гэрээ гүйцэтгүүлээ. /100%/</p>
		<p>Байгууллагын удирдлагын албан хэрэгцээнд авто машин худалдан авах ТБОНӨХБАҮХАТ Хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалт явуулж, үнэлгээний хорооны даргаар ажлан “Монгол Хьюндай Автомотив ХХК”-тай “Бараа нийлүүлэх гэрээ” байгуулан, акт үйлдэж Сонато YF маркын авто машиныг хүлээж авсан. /100%/</p>
<p>Сүлжээ, холбоо болон техник хангамжийн хэвийн ажиллагааг хангах</p>		<p>Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан аливаа үйл ажиллагааны сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байв. Мөн сургалтын төхөөрөмжүүдэд утасгүй мэдээлэл солилцох боломж гарган WiFi Projector, WiFi Smart TV, Desktop computer WiFi, Notebook WiFi, Smart Phone Shared хийсэн. /100%/</p> <p>Сүлжээ, холбооны хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд Силикон Хаус төслөөр нийлүүлэгдсэн сүлжээний болон бусад т. т-ийг үзүүлэлтийн дагуу хүлээн авч, дотоод сүлжээний ерөнхий топологи зураг, төхөөрмжүүдийг зогсуурт суулгасан зураг зэргийг гаргах, Серверийн өрөөний аюулгүй хэвийн ажиллагааг хангах, Firewall тохиргоо хийх, Сүлжээний бүтэц, зохион байгуулалт, хамрах хүрээ, хандах эрхийн матриц гаргах, Сүлжээний төхөөрөмжүүдийн хамгаалалт нууцлалын зэргийн болон хэрэглэгчийн нууцлалын зэргийн хүснэгт үүсгэн хөтлөх, байрлуулах, компьютер сүлжээний т.т-ий судалгаа хийх, Firewall,router, switch, server password (нууц үг)-ийг 30 хоногт 1 удаа шинээр хийх, Телефон утасны шугмыг серверийн өрөөнд байрлуулах зэрэг ажлыг гүйцэтгээд байна. Одоогийн байдлаар интернэт үйлчилгээг Комтел ХХК-аас 30mbps авч байна. 11 ширхэг рейл ай пи хаяг ашиглагдаж байна. Байгууллагын дотоод сүлжээний хурд 1gb хурдтай. /100%/</p> <p>Програм хангамжтой холбоотойгоор дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Mac All in One Password restart програм болон Projector програмуудыг CD дээр бичсэн. 2. Програм хангамжийн стандарт тогтоох зорилгоор компани бүх ажилтнуудад outlook ашиглах болон Teamviewer, fbackup суулган, ашиглах зааварчилгаа өгч, үйл ажиллагаанд ашиглаж байна. 3. Интернэт урсгал хяндаг програм суулгасан 4. Байгууллагын бүх ажилтнуудад дотоод сүлжээний мессенжер суулган үйл ажиллагаандаа ашиглаж байна. 5. Серверийн програм хангамж (Интерактив) хийх ажлыг эхлүүдээд байна. 6. Шинээр MAC OS-10, Windows OS-35 удаа суулгасан /100%/

1.2.	Олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулах	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Эх орныхоо үзэсгэлэнт байгалтай танилцан, ай сав газрын хог хаягдлыг цэвэрлэх зорилгоор Өвлийн аялалыг Тэрэлжид, Зуны аялалыг Хөвсгөл аймагт тус тус зохион байгууллаа. /100%/
			2014 онд байгууллагын ахмад настангуудыг 2 удаа хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ. /100%/
			9-р сард ЦСҮТ -тэй хамтран "Амьдрал бэлэглэе" өдөрлөгийг зохион байгуулж, байгууллагын ажилчидад цусаа бэлэглэхийн ач тус сэдэвт сургалтыг ЦСҮТ-н мэргэжилтэн ирж сургалт хичээл орж, ажилчид сайн дураараа цусаа хандивлан. Салбарын байгууллагууддаа үйл ажиллагаанд нэгдэхийг уриаллаа. /100%/
			Түрээслэгч байгууллагуудтай хамтран байгууллагын байрны урд хэсгийн талбайг зүлэгжүүлэн хашаа хийв. /100%/
		Өглөөний цай арга хэмжээ зохион байгуулах	Ажилчдын дунд халуун дулаан уур амьсгал, бүрдүүлэх, мэдлэг мэдээлэлээ солилцох, сонирхолтой арга хэмжээ зохион байгуулах үүднээс 2014 онд Өглөөний цай алга хэмжээг нийт 6 удаа зохион байгуулсан бөгөөд тус бүрдээ тодорхой нэгэн зорилго агуулгатай байсан. 2013 оны 1-р сард Хүндэт зочиноор МУИС-н багш философич Жамбал багшийг зочиноор урин сонирхолтой яриа өрнүүлэв. 5-р сард хүүхдийн баярыг тохиолдуулан бяцхан үрсээ хүлээн авч гарын бэлэг гардууллаа. 9-р сарын Өглөөний цай арга хэмжээнд Инкубаторын компаниудын төлөөлөл Алкемист техноложис, SIS компаниуд оролцсоноороо онцлогтой байв. 10-р сард инкубаторын компаниудтай хамтран Halloween 2014 сэдвийн доор хөгжөөнт уралдаан тэмцээн зохион байгууллаа. /100%/
		Биеийн тамир, чийрэгжүүлэлт, спортоор хичээллэх үйл ажиллагаа зохион байгуулах	Ажилчидын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж 7 хоног бүрийн 2 дахь өдөр спорт зааланд хамруулж байв. Мөн ажилчдын хүмэлтийн дагуу Цахилгаан холбоо ХХК, Амжилт фитнес клубүүдэд 7 хоногт 3 удаа хичээллэх боломжийг бүрдүүлж ажиллав. /100%/
		Харилцаа холбооны 93 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төрийн болон салбарын шагналд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулах	Ажилдаа үр бүтээл гаргасан ажилтнуудаа салбарын шагнал урамшуулалд тодорхойлж Салбарын 93 жилийн ойн баяраар "Салбарын тэргүүний ажилтан" цол тэмдэгээр-1, "Салбарын жуух" бичгээр-1 ажилтан шагнагдлаа. /100%/
	Байгууллагын ажилчдын нийгмийн асуудалд чиглэсэн үйл ажиллагаа явуулах	Хас банк болон Сайн компьютерстай хамтран ажилчдыг урт хугацааны Зээлийн үйлчилгээнд хамрууллаа. /100%/	
		2014 оны 6-р сард Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд ажилтнуудыг хамруулсан бөгөөд 29 ажилтнаас 26 ажилтан хамрагдсан. Эмнэлгийн үзлэгийн дүгнэлтээр гарсан хариуг бүх ажилчдад танилцуулан, өвчлөлтэй гарсан ажилчдад эрүүл мэнддээ анхаарч эмчилгээ үйлчилгээ хийлгэх тал дээр анхаарч ажилласан. Мөн ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор өдөр бүр 10:00, 15:00 цагт тус бүр 10минутын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлээд байна. /100%/	
	Байгууллагын түүхийн ном гаргах	Байгууллагын түүхийн номны материалыг нэгтгэн, редакторлах болон эх бэлтгэлийн ажлыг дуусагсан бөгөөд Цогт принт хэвлэлийн компанитай гэрээ хийгээд байна. /80%/	

1.3.	Хүний нөөцийн үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих	<p>Байгууллагын хамтын ажиллагаа, Ажлын байрны соёл, Цагийн менежмент, Стресс менежмент, Хувийн зохион байгуулалт, Монгол улсад нээлттэй өгөгдлийг үүсгэх боломж, Англи хэлний сургалт, photo shop-ын гэсэн 8 сургалтыг байгууллагын болон инкубаторын компаниудын ажилчдад зориулан зохион байгуулж давхардсан тоогоор 160 гаруй ажилтан хамрагдлаа. Ажилчдын ур чадварыг дээшлүүлэх мэргэжлийн 8 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 10 хүн хамрууллаа. Байгууллагын дэмжлэгтэйгээр 2 хүн Их сургуулийн мастерт суралцаж байна. /100%/</p> <p>Ажлын байрны зар мэдээллийг тогтмол байгууллагын веб сайт болон biznetwork.mn, FB хуудас зэргээр тогтмол явуулж, ажил гориллогчдын ирүүлсэн анкет материалыг удирдлагуудад танилцуулан сонгон шалгаруулалтанд оролцуулж байв. 2014 онд нийт 7 нээлттэй ажлын байр дээр 60 гаруй анкет хүлээн авч сонгон шалгаруулалт хийсэн ба өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 7 ажилтан, тэтгэвэрт 1 ажилтан, жирэмсний амралтанд 1 ажилтан тус тус гарсан. Нээлттэй ажлын байранд 9 ажилтан томилогдон ажиллаж байна. /100%/</p>
1.4.	Байгууллагын эрх ашгийг хамгаалах, хууль эрх зүйн асуудлыг шийдвэрлэх	<p>Ц.Баасандорж, А.Ууганбаярын нэхэмжлэлтэй иргэний хэрэг болон Дүйнхэр Тэргүүн ХХК, Колорфул квалити ХХК-нд холбогдох иргэний хэргүүд нь Монгол Улсын Дээд шүүхээр тус тус эцэслэгдэж шийдвэрлэгдсэн. /100%/</p> <p>Ажил дүгнэх журам цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор хойшлогдсон. Нийт 11 журам батлагдсан. Үүнд: 1.Хөдөлмөрийн дотоод журам, Дотоод хяналт шалгалтын журам, Архивын журам, Инкубаторын үйл ажиллагааны журам, Шуурхай ажлын зааварчилгаа, Нууцын журам, Хаяг реклам байршуулах журам, Илүү цагаар ажиллах маягт, Зорилтот салбар буюу эмэгтэйчүүдийн икубаторын үйл ажиллгаааны журам, Оффисийн дотоод журам зэргийг батлуулсан. /100%/</p> <p>Нийт 93 ширхэг гэрээ хэлцэл, 4 ширхэг санамж бичиг байгуулсан. Үүнээс түрээсийн гэрээ 35ш, Ажил гүйцэтгэх гэрээ 24 ширхэг, хамтран ажиллах гэрээ 12 ширхэг, худалдах худалдан авах гэрээ 5ш, тоног төхөөрөмж түрээслэх болон бартерийн гэрээ тус тус 3ш батлуулсан нь дийлэнх хувийг эзэлж байна. /100%/</p> <p>Байгууллагын эрх зүйн асуудлаар ТӨХ-д санал оруулан хорооны хурлаар ААТҮГ-ын статустайгаар батлагдан ЗГ-ын хуралдаанаар орохоор хүлээгдэж байна. /100%/</p> <p>2014 оны төлөвлөгөөг АТГ-р батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. /100%/</p>
1.5.	Гадаад харилцаа, маркетингийн үйл ажиллагаа	<p>БНСУ-ын олон улсын байгууллага болх KISA-ийн Digital manegment, Internet address policy, Security Managemen сэдэвт 5-14 хоногийн сургалтанд 3 мэргэжилтэн хамруулав. /100%/</p> <p>Солонгосын Тэжон хотод болсон Дэлхийн Технополисийн Холбооны 9 дүгээр Ерөнхий Ассемблей (WTA)-д МТҮП болон инкубаторын компанийн төлөөллөөс бүрдсэн 14 хүн хамрагдсан. Үүнээс WTA-UNESCO хамтарсан сургалтанд 4 хүн, Глобал инновацийн чуулганд 4 хүн, инкубаторын компани болох Graffx -ээс 5 хүн WTA Hi-Tech Fair үзэсгэлэнд туршлага судлах үүднээс тус тус амжилттай оролцсон. /100%/</p>

		<p>Солонгосын ITU&KIV байгууллагын сайн дурын 2 багийн 8 ажилтан уригдан ирж ажиллаа. I-р баг /A202/ 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр 7.17 - 31 хооронд МТҮП-ын ажилчид болон инкубаторын компаний ажилчдад солонгом хэл, фотошопын хичээл орсон бол II-р баг /4BIT/ 717 - 8/22 хооронд "Робот кар" төсөл дээр паркийн ажилчидтай хамтран ажиллаа. Төслийн үр дүнд Робот карын Моторын хөдөлгөөнийг интернетээр удирдсан. Урагш хөдлөх ба баруун, зүүн тийш, зогсоох гэсэн 4 үйлдлийг удирдана. Raspberry Pi-д dc toy motor, L298N motor driver-г холбож Python програмчлалыг бичиж ажиллуулж, дээрх элементүүдийн холболтыг хийв. /100%/</p> <p>Олон улсын ACM (Association for Computing Machinery-Цахим тооцооллын холбоо)-ын гишүүн байгууллага болсон. Ач холбогдол нь дэлхийн шилдэг ном, хэвлэлүүд ялангуяа MT-ийн чиглэлийн номыг захиалах, унших, түүнчлэн дижитал номын санг ашиглах боломжтой болж байна. /100%/</p> <p>2012 онд туршлага, мэдлэг солилцох, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, хөгжлийн загварыг нэвтрүүлэх, хамтран ажиллах зорилгоор ASPA-ийн гишүүнээр элсэж байсан. Энэхүү давуу эрхүүдээ үргэлжлүүлэн эдлэх үүднээс МТҮП нь ASPA-ийн гишүүнчлэлээ 2014 оны 10-р сарын 02-нд сунгалаа. /100%/</p>
1.6.	Санхүү, төлөвлөлтийн үйл ажиллагаа	<p>Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх, тайлагнах</p> <p>Хуулийн хугацаанд тайлагнах бүх тайланг хугацаанд нь гаргасан. Мөн нэмэлт төслийн аутсорсингийн тайланг ЗГХЭГ-т тайлагнаж 4,9 сая төгрөгийн үлдэгдлийг хаасан. ТӨХ-нд түрээсийн болон ҮХ-тэй холбоотой уламжлалт ТӨ-2 маягыг бөглөж тайлан хэлбэрээр гаргаж өгсөн. "Сүлд" аудитын шалгалттай холбоотой 19 асуулга, дүгнэлтэд хариу тайлбар хийж хүргүүлсэн. Үндэсний аутидын газраас ирүүлсэн 2013 оны тайлан мэдээтэй холбоотой тайланг цаг хугацаанд нь үнэн зөв бэлтгэж ажиллаа. Сангийн Яаманд 2013 оны тайлан мэдээг маягтын дагуу 2 удаа хүргүүлсэн. Санхүүгийн хянат шалгалттай холбоотойгоор ТӨХ-ны мэргэжилтэн Жанцанхорлоод 2012-2013 оны бүх мэдээллийг гаргаж өгч, шалтгалтаар зөрчилгүй дүгнэлт гаргасан. /100%/</p>
	Байгууллагын мөнгөн болон биет хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах	Байгууллагын мөнгөн хөрөнгийн орлого зарлагын тайланг өдөр тутам анхан шатны баримтаар баталгаажуулан 7 хоног тутам орлого-зарлага, түрээсийн тооцоо мэдээллийг удирдлагуудад тайлагнаж хэвшсэн. /100%/
	Байгууллагын 2013 оны жилийн эцсийн тооллогоор актлах хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулах	Үндсэн хөрөнгийн бүртгэлгүй БМ-аас ажилчидад актлаж 606.000 төгрөгийн орлогыг үндсэн бус үйл ажиллагааны орлогод бүртгэсэн. 1.2 сая төгрөгийн үлдэх өртөгтэй соната-5 машиныг актлуулахаар ТӨХ-д өгсөн боловч буцаагдсан. /90%/
	Байгууллагын түрээсийн үйлчилгээг сайжруулж төсөвлөсөн орлогыг бүрдүүлэх	Сар бүрийн түрээсийн төлбөрийн нэхэмжлэхийг тухайн сарын 5-ны дотор тараан, тооцоог гэрээний хугацаанд барагдуулах талаар байгууллагуудаас шаардан барагдуулах зарчимаар ажиллаж байна. /100%/
	Санхүүгийн НББ-ийн шинэ програмтай болох	BAAZ програм дээр тайлан баланс хөтөлж байна. /100%/
	Байгууллагын 2014 оны батлагдсан төсвийн дагуу худалдан авалтын жагсаалт гаргах	• Худалдан авалтын жагсаалтыг гарган ТӨХ-оор батлуулан 2014 онд нийт 109.3 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн. /100%/
2	Цахим засаглал, статистик хэрэгжүүлэлтийн чиглэлээр	

2.1.	<p>Байгууллагын стратеги үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийх</p>	<p>Байгууллагын 2015 оны хийгдэх ажлын төлөвлөгөөнд 2021 онд төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтот хөтөлбөртэй танилцан дараах 4 төслийн нэр оруулав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. МУ-ын үндэсний онцлогт тохирсон "Инновацийн үйлчилгээ" буюу "Инновацийн гурвалсан загвар" дээр суурилсан Мэдээлэл, холбооны өндөр технологийн инновацийн кластерийг үе шаттайгаар байгуулах 2. Хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн иргэдэд МТ-ийн боловсрол, мэргэжлийн бэлтгэл олж авах сургалтанд тэгш оролцох боломжийг хангах зорилгоор зуны сургалт зохион байгуулах 3. Ногоон МТ-ийн Аллиансе байгуулж ногоон технологийн үндэсний хөтөлбөр гаргах, хэрэгжилтийн талаар мэдээллийн сан, платформыг үүсгэн байгуулах 4. МТ, програм хангамжийн чиглэлээр гадаад зах зээл дээр ажиллах чадвар бүхий мэргэшлийн ажилтан бэлтгэх үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр гаргах /100%/
	<p>МУ-ын хууль тогтоомжийн дагуу НӨАТ, ҮХЭХАТ-аас чөлөөлөгдөх хүсэлтийг /21 хуудас бүхий материалыг хавсралт материалын хамт/ ТЕГ, нийслэлийн ТГ, СБД-ийн ТГ-т тус тус илгээсэн. Үүний үр дүнд: 1. Сургалтаас орж ирж буй бүх орлого НӨАТ-аас чөлөөлөгдөж эхэлсэн бөгөөд нийт 35.5 сая төгрөгийн орлогын 10% НӨАТ-аас чөлөөлөгдсөн байна./ТЕГ-аас сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байгууллага НӨАТ-аас чөлөөлөгдөж болно гэсэн хариу нь татварын элдэв асуудалд хүргэхгүй баталгаажуулалт болж өгсөн/2. ҮХЭХТ-тай холбоотойгоор ТЕГ-аас ирүүлсэн албан бичигт дурдсанаар: Үйлдвэрлэл технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн 10-р зүйлийн 10.3, 11.1.2-т тус тус заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй этгээдтэй гэрээ байгуулан тухайн паркын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд ҮХЭХАТ-аас чөлөөлнө гэсэн хариу ирүүлсэн нь дараагийн алхам хийхэд чиг үүрэг, гарцыг бий болгож чадсан үр дүнтэй ажил болж чадсан. /100%/</p>	
	<p>"МТҮП-II" төслийн хүрээнд Шинжлэх ухааны технологийн парк байгуулах 8 чиглэлийн дэд төсөлтэй, дэлхийн банкнаас олгох 9 тэрбумын хөрөнгө оруулалтын 20 хуудас танилцуулга бэлтгэсэн. 8 чиглэлийн дэд төсөл:</p> <ul style="list-style-type: none"> • Програм хангамжийн аудит газар • Програм хангамжийн тестийн төв • Электроник систем хөгжүүлэлтийн лаборатори • Эмэгтэйчүүдийн бизнес түншлэлийн төв • МТИШ буюу хүний нөөц бэлтгэх, онлайн сургалтын төв • Дотоод сүлжээ болон бусад тоног төхөөрөмжийн шинэчлэл • МТ-ийн номын сангийн фонд баяжуулалт • Барилгын их засвар /100%/ 	

		<p>"МТҮП-II" төслийн хүрээнд ПХ тестийн төв болон ПХ аудитын газар байгуулах төслүүдийн арга зүйн тойм, МУ-ын өнөөгийн байдал, ОУ-ын туршлага, хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэх боломж, ач холбогдол, хууль эрх зүйн орчин, техник технологийн орчин, хүний нөөц байгууллагын бүтэц зохион байгуулалт, санхүүжилт төсөв хэрэгцээт хөрөнгө оруулалтын хэмжээг судлаж нэгтгэсэн 68 хуудас бүхий танилцуулга бэлтгэн ажилчид болон "Mobicom" ХХК-ийн ахлах аудитор танилцуулж санал бодлоо хуваалцан, харилцан ярилцасны үндсэн дээр програм хангамжийн тестийн төв байгуулах төсөл дээр үндэслэгдэн програм хангамжийн аудитын газар байгуулах төслийг эхлэх шийдвэрт хүрсэн. Үүний дагуу ПХ тестийн төвийн хэрэгцээ шаардлагын судалгааг IT consulting ,програм хангамж хөгжүүлэгч,бизнесийн байгууллага гэсэн 3 чиглэлээр нийт 83 байгууллагаас авлаа. Судалгаанд оролцогчдын 60 хувь нь тестийн төвийн хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн. /100%/</p> <p>Инкубаторын үйл ажиллагааны элсэлтээс гадна одоо байгаа бааз суурь дээр үндэслэн зорилтод түвшний салбарыг дэмжих чиглэлээр эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зкорилгоор Анхны "Эмэгтэй МТ-ийн компанийг дэмжих" төсөл боловсруулан үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд нэмэлт журам боловсруулан олон нийтэд мэдээлсэн. Элсэлтийг журмын дагуу 1 сарын өмнө холбогдох сайт, олон нийтийн сайтуудаар мэдээлэв. Мөн семинар зохион байгуулж нийт давхардсан тоогоор 20 гаруй эмэгтэйчүүд ирж зөвлөгөө авсан байна. /100%/</p>
3	Силикон Хаусын үйл ажиллагааг тогтмолжуулах	
3.1	Номын сангийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулах, үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах	Номын сангийн фондын бүрдүүлэлтийг Азийн хөрөгө оруулалтын сан, түүнчлэн элчин сайдуудын яам, холбогдох газрууд руу албан бичиг илгээн 2000 гаруй номоор бүрдүүлсэн. Амазоноос 920 гаруй \$ ном захиалсан. Үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор номын сангийн журмыг боловсруулан батлуулж үйлчилгээний тарифыг тогтоосон. Олон нийтэд мэдээлсэн. Номын сангийн программыг шинээр хөгжүүлэлт ашиглахад бэлэн болсон. /70%/
3.2.	Сургалтын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах	МТ-ийн чиглэлээр төлбөртэй, сертификаттай дараах 11 сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд: Мэдээллийн аюулгүй байдал, Oracle, Firewall, PHP, IOS, Android, Linux, CPANEL, Active directory, МТИСШ бэлтгэх сургалт, МТПШ бэлтгэх сургалт. Энэхүү мэргэшүүлэх сургалтанд хөдөө орон нутаг болон нийслэлийн төрийн болон хувийн хэвшлийн 327 мэдээллийн технологийн мэргэжилтнүүд хамрагдан сертификат авсан байна. Сургалтанд оролцогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгаанаас харахад дээрх сургалтууд нь эрэлт хэрэгцээнд тулгуурласан, зохион байгуулалт, чанар сайн байна. Цаашид МТ-ийн ахисан түвшний сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. Дээрх сургалтуудаас нийт 45,650,000 төгрөгийн орлогыг олсон ба 34,953,796 төгрөгийн ашигтай ажилласан бол танхимын түрээсээр 41 байгууллага сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2784 иргэнийг хамруулан 10.640.000₮ орлогыг МТҮП-ийн төсөвт оруулсан байна. /100%/

		Боловсролын яамнаас эрх бүхий байгууллагад олгодог боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах зөвшөөрлийн эрхийг 2015 оны 10 сарын 27-ныг дуустал авсан. Сургалтын төвийн журмыг боловсруулан батлуулсан. /100%/
3.3	Электроник систем хөгжүүлэлтийн лабораторийн үйл ажиллагааны нээлт, өргөжүүлэх, тогтмолжуулах	<p>Судалгаа шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор дараах туршилтуудыг хийсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Интерактив систем ХХК Зоорьны Температурын хяналтын систем, Ухаалаг гэрийн автоматжуулалт, GPS ашигласан удирдлагын систем, 2. Хайрхан Семикондакторс ХХК-нд USMS буюу Unified Site Monitoring System ийг хэрэгжүүлэхэд, 3. МУИС-ийн ЭХИ-ийн тэнхимийн оюутнууд “Гэрийн автоматжуулалт”, “Beaglebone хавиан ашигласан хөдөлгөөнт объект дагагч”, “Дохионы хэлний цагаан толгойн үсэг танигч”, “Raspberry Pi ашигласан 3D камер”, PCA ашигласан царай таних төхөөрөмж” 4. ШУТИС-ийн ХМС-ийн оюутнууд автомат болон гар удирдлагатай робот бүтээв. 5. МХМС-ийн багш, оюутнууд Sparta 6 board ашиглаж лабораторит судалгаа шинжилгээний туршилтын ажил /100%/ <p>БНХАУ-ын Shenzhen дахь Электроникийн томоохонд тооцогддог захыг судлан PCB(Printed circuit board) үйлдвэрлэлийн чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг, тухайн салбарт дээгүүр эрэмбэлэгддэг 3-5 компанитай харилцаа тогтоож цаашид iPCB үйлчилгээг үзүүлж, хамтарч ажиллах боломж нээгдсэн. Энэ нь манай электроникийн салбарт тодорхой түлхэц болохуйц ач холбогдол бүхий харилцаа холбоо тавигдсан. /100%/</p> <p>Лабораторийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ашиглалтын журмыг гарган вэбэд байрлуулан олон нийтэд танилцуулсан. Түүнчлэн хэрэглэгчийн үүрэг хаиуцлагийг дээшлүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ЭС-ийн бүртгэлийн програм хангамж хөгжүүлэлтийн шатанд явж байна. /100%/</p>
3.4.	Компьютер вишн лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэх, нээх, үйл ажиллагааг тогтмолжуулах	<ol style="list-style-type: none"> 1. Компьютер вишн лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор ашиглалтын журам боловсруулан олон нийтэд танилцуулсан. Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор зарим тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй ашиглуулах үйлчилгээг явуулж ирлээ. 2. Компьютер вишн лабораторид Силикон хаус төслийн нээлт, Азийн шинжлэх ухааны паркуудын 9 дэх удаагийн уулзалт, MNSEC 2014 семинар, Social good summit, ADVENCED WEB TECHNOLOGIES IN MONGOLIA семинар, Start up Mongolia семинар, монголын ПХ-ын үйлдвэрлэгчдийн салбарын 2-р чуулган, Mobile ICT фестиваль зэрэг 8 томоохон үйл ажиллагаа зохион байгуулав. /100%/
4	Салбарын хүний нөөцийг чадваржуулах	

4.1.	<p>MT-ийн мэргэжлийн сургалт семинаруудыг зохион байгуулах</p>	<p>CC, ERP - ийн чиглэлээр MT-ийн мэдлэгийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, анхан шатны мэдлэг олгох зорилгоор Advanced web technology болон big data арга хэмжээг 2014 оны 10-р сарын 24-нд зохион байгуулсан. Үйл ажиллагаанд MT-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын удирдлагууд, их дээд сургуулийн багш нар веб технологи, интернэт технологийн чиглэлээр илтгэл тавьж, оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд 120 орчим хүн хамрагдсан. /100%/</p> <p>"Эмбэдэд систем Монголд " онол практикийн бага хурлыг зохион байгуулж нийт 70 гаруй оролцогч нарыг хамарсан, Монгол улсын MT-ийн хөгжил чиг хандлагын талаар хэлэлцүүлэг хийв. /100%/</p> <p>Андройд, iOS сургалтанд 21 хүн хамрагдсанаас 19 нь шаардлага хангаж сертификат гардан авсан бөгөөд сургалтын үр дүнд 8 апплейкешн гаргасан. /Тооны машин 2ш, TV Radio stream, Эмч нарын мэдээлэл, Дэлгүүрийн мэдээлэл, Электроник, Рубик шоо, Утасны лавлах/ 2014 онд Мэдээллийн аюулгүй байдал, Oracle, Firewall, PHP, IOS, Android, Linux, CPANEL, Active directory, МТИШ бэлтгэх сургалт, МТПШ бэлтгэх сургалт гэсэн 11 сургалт зохион байгуулж нийт 367 хүн хамруулаад байна. Энэ жил MT-ийн чиглэлээр зохион байгуулдаг сургалтуудын нэр, төрөл нэмэгдсэнээс гадна МТИШ-ын хүрээнд зохион байгуулдаг сургалтуудыг хөдөө орон нутагт зохион байгуулах болсоноороо онцлогтой байлаа. /100%/</p>
5	МТИШ-ыг зохион байгуулах, цар хүрээг өргөжүүлэх	
5.1.	Асуулт боловсруулах үндэсний зөвлөл ажиллуулах, хурал зохион байгуулах	<p>АБҮЗ-ийн нийт 12 удаагийн хурлыг зохион байгуулж, MT-ийн инженерийн шалгалтын зөвлөл (ИПЕС)-д нийт 102 асуулт хандивласан байна. Үүнээс 2014 оны намар, 2015 оны хаврын шалгалтуудад нийт 14 асуулт тэнцэж, Монгол улс тэнцүүлсэн асуултын тоогоороо 1-р байрт шалгаран өндөр амжилт үзүүлээд байна. Мөн АБҮЗ-ийн гишүүдийн үндсэн болон урилгаар оролцож буй гишүүдийн нийт тоо 22 болоод байна. /100%/</p>
5.2.	МТИШ-ыг зохион байгуулах, үйл ажиллагааг тэлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, шалгалт зохион байгуулах	<p>МТИШ-ын цар хүрээг өргөжүүлэн Интерактив ХХК, Интерактив Би Ай ХХК, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК зэрэг бизнесийн болон төрийн байгууллагуудтай хамтран тухайн байгууллагын ажилчдыг МТИШ-нд бэлтгэх сургалт болон МТИШ-нд хамруулсан. Нийт 2014 онд 287 шалгуулагч хамрагдсанаас 24 шалгуулагч амжилттай дүн үзүүлж шалгалтанд тэнцсэн байна. Энэ жил өмнөх жилүүдтэй харьцуулахад хамгийн их шалгуулагч хамрагдсан нь том амжилт байлаа. /100%/</p> <p>Ховд аймгийн Ховд их сургууль дээр 12 сарын 05-ны өдөр анх удаа туршилтын журмаар MT-ийн паспорт шалгалтыг зохион байгуулсан бөгөөд тус шалгалтанд Ховд аймгийн ЗДТГ болон сумдуудын төрийн байгууллагын ажилчид хамрагдсан байна. Нийт шалгалтанд 46 шалгуулагч хамрагдсанаас 3 шалгуулагч тэнцэж амжилттай дүн үзүүлсэн байна. /100%/</p>

		<p>МТИШ-ын цар хүрээг нэмэгдүүлэх, цаашлаад МТ-ийн боловсролыг дээшлүүлэх, тэр дундаа төрийн албан хаагчдыг мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2014 оны 10.15-нд ТАЗ-тэй хамтран ажиллах санамж бичиг үзэглэв. Санамж бичгийн хүрээнд хэд хэдэн удаа ТАЗ-ийн даргатай хамтарсан уулзалт зохион байгуулж стандарт боловсруулах, асуултын сантай болох, сургалт, шалгалтыг зохион байгуулахаар болсоны дагуу МТҮП дээр 7 бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан эхний ээлжинд стандарт боловсруулах албан хүсэлтийг ХХЗХ руу илгээгээд байна. /100%/</p> <p>Бангладеш улсад 9.3-5-нд МТИШ-ын гишүүн орнуудын захирлуудын уулзалт зохион байгуулагдсан бөгөөд уг уулзалтаар гишүүн орнуудаас хамгийн өндөр оноо авсан 1 шалгуулагчийг япон улсын МТ-ийн компаниудтай танилцах, харилцан туршлага солилцох үүднээс 2 сарын 22-оос эхлэн долоо хоногийн хөтөлбөрт аялалыг зохион байгуулахаар болсон. Монгол улсаас МУИС-ХШУИС-ийн оюутан У.Наранбаяр шалгараад байна. /100%/</p>
6	Бизнесийн инкубацийн орчинг сайжруулах, инкубаторыг ажиллуулах чиглэлээр	
6.1.	Инкубаторын сонгон шалгаруулалт, үнэлгээ, дүгнэлт хийх	<p>Инкубаторын элсэлтийг 4 удаа зохион байгуулав. 21-24 дахь шаргаруулалтанд оролцогчдод зориулсан семинарыг 8 удаа зохион байгуулж нийт 90 гаруй иргэн болон компаний хамрагдсанаас 1 иргэн 10 компани элсэн орсон. 24 дэх элсэлт 12-р сарын 26 нд болно. /100%/</p> <p>Хагас жилийн үнэлгээг нэг удаа зохион байгуулсан бөгөөд үнэлгээнд 8 компани орсоноос Сэбшн ХХК 70 хувиас доош үнэлгээ авч Инкубаторын журмын дагуу хасагдсан бол сарын үнэлгээг 7 удаа хийж, We can do systems ХХК нь сар бүрийн үнэлгээгээр 3 сар дараалан 60 хувиас доош үнэлгээ авсан тул журмын дагуу хасагдсан байна. Одоогийн байдлаар 9 компани үргэлжүүлэн инкубаторын үйлчилгээг авч байна. /100%/</p>
6.2.	Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үйлчилгээ үзүүлэх	<p>1. Багаар ажиллах арга зүй, Компанийн, бизнесийн стратегийг боловсруулах арга зүй, Бүтээлч сэтгэлгээ ба шинийг санаачлах чадвар, Бага бүрдүүлэх, удирдах арга зүй, Хүний нөөцийн сургалт, Санхүүгийн бичиг баримт хөтлөлт, Албан бичиг боловсруулалт, Маркетинг, Цагийн менежмент гэсэн 10 сургалт зохион байгуулж нийт давхардсан тоогоор 150 орчин хүн хамрагдсан.</p> <p>2. Инкубаторын компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах, хэрэглэгчтэй холбох зорилгоор ICTA ехро, Силикон Хаусын нээлт, АСПА, Салбарын нээлттэй хаалганы өдөрлөг, Програм хангамжийн 2-р чуулган зэрэг үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан 5 үзэсгэлэнд оролцуулсан. Мөн МТШХХГ-ын даргатай уулзалт зохион байгуулж, бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа танилцууллаа. /100%/</p>

		<p>1. Багц үйлчилгээг хэрэгжүүлэх зорилгоор Инкубаторын Graffx ХХК-ийн БНСУ-д болсон WTA Hi-Tech Fair үзэсгэлэнд оролцуулан туршлага судлуулсан.</p> <p>2.Зүүн өмнөд Азийн гарааны бизнесүүдийг дэмжих эко систем, санхүүжилтийн механизм, тэр зах зээлд Монгол компаниудын гарах боломж сэдэвт уралдаанд инкубаторын Алкэмист техноложис ХХК түрүүлж БНСУ-д болох Старт-ап-д оролцох эрх авсан. /100%/</p> <p>Графикс, Хайрхан семикандакторс, EASS, Интерактив систем, Алкэмист техноложис гэсэн 5 компанид лабораторын үйлчилгээ үзүүлсэн. /100%/</p> <p>Инкубаторт элссэн 11 компанид 8 багц үйлчилгээ үзүүлэхээс тухайн компаний шаардлагаас хамааран тамганы үйлчилгээ 1 компанид, танилцуулга материалын загварыг 8 компанид, серверийн эрхийг 8 компанид, цогц сургалтыг -11 компанид, ажлын байрны түрээсийг журмын дагуу 11 компанид, дотуур холбооны утасыг 1 компанид, интернэт үйлчилгээ 11 компанид, Бизнесийн гарааны цүнхийг 2 компанид тус тус үйлчилгээ үзүүлж ажиллаа. /100%/</p> <p>Инкубаторын компаниудын захирлын уулзалтыг 14 удаа зохион байгуулж, сарын тайлан, дараа сарын төлөвлөгөөтэй холбоотой заавар, зөвлөгөө өгч ажиллаа. Мөн хамтын ажиллагааны хүрээнд Инкубаторын танилцах өдөрлөг, Инкубаторын компаниудын спорт өдөрлөг, МТҮП-ын 10-р сарын өглөөний цай арга хэмжээг хамтран зохион байгуулах, Салбарын 93 жилийн ойн үйл ажиллагаанд хамтран оролцох г.м үйл ажиллагааг зохион байгууллаа. /100%/</p>
7	Шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэлтийг дэмжих чиглэлээр	
7.1.	Инкубаторын платформ өргөтгөх	Инкубаторын платформын эхний хувилбарыг бэлэн болгож өнгөрсөн 6 сард ашиглалтанд оруулж incubator.itpark.mn домайн дээр байрлуулан инкубаторын компаниудыг бүртгэж авсан. 6 сараас хойш платформыг өргөжүүлэн хөгжүүлсээр одоогийн байдлаар инкубаторын 12 компанийг бүртгэн авсан. Платформоор компаниудын сар, хагас жилийн тайлангуудыг хүлээн авах, тайланд үнэлгээ хийх, компаниудад зар түгээх, санал асуулга авах, олон нийтэд инкубаторын үйл ажиллагаа болон инкубаторын компаниудыг танилцуулах зэрэг үйл ажиллагааг илүү боловсронгуй болгож чадсан. /100%/
7.2.	Асуулт боловсруулах зөвлөлийн платформыг өргөтгөх	2013 онд АБЗ-ийн платформ МТИШ-ын өглөөний шалгалтын асуултыг хэлэлцэх боломжтой болсон. 2014 онд МТИШ-ын өдрийн шалгалт нь 2-3 хуудас бүхий А4-ийн цаасны хэмжээний урттай ба зураг график, математикийн томъёоны дүрс зэрэг олон төрлийн форматтай текстээс бүрдэж байгаа г.м асуултуудын онцлогоос шалтгаалан цаашид хөгжүүлэлтийг зогсоосон. /30%/
8	Хамтын ажиллагаа болон бусад арга хэмжээ	

8.1.	ОУ-ын хурал зохион байгуулах		<p>2014 оны 6.19-21-ны өдрүүдэд өөрийн байранд анх удаа Азийн шинжлэх ухааны паркуудын холбооны 9 дэх удаагийн уулзалтыг амжилттай зохион байгуулсан. Тус уулзалтанд солонгос, япон, тайван, вьетнам, туркийн гэх мэт 6 дэмжигч орон хамтран ажиллаж, 100 гаруй зочид, төлөөлөгчид оролцсон байна. Уулзалтын үр дүнд инкубаорын 2 компани БНСУ-ын компанитайх амтран ажиллах зөвшилцөлд хүрсэн. /100%/</p> <p>МТ-ийн инженерийн шалгалтын зөвлөл (ИПРЕС)-ийн ОУ-ын асуулт боловсруулагчдын уулзалт 2014 оны 6.4-6 ны өдрүүдэд зохион байгуулав. Тус хурлаар 2014 оны намрын МТИШ-ын асуултуудыг хэлэлцэн, сонгон шалгаруулсан. Нийт 8 орны 27 оролцогч хамрагдсан. Хурлаар нийт 3,127,050 төгрөгний орлого орсон. /100%/</p>
8.2.	ICTЕхро болон салбарын ойн бусад арга хэмжээнд оролцох	<p>МХХТ-ын салбарын ICT үзэсгэлэн 2014</p> <p>Салбарын эрдэм шинжилгээ спортын арга хэмжээ</p> <p>Салбарын 93 жилин ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ</p>	<p>5-р сарын 22-26 ны өдрүүдэд зохион байгуулагдсан ICTА ехро-2014 арга хэмжээнд инкубаторын 7 компаний хамт байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан оролцлоо. /100%/</p> <p>Дарц, эрэгтэй эмэгтэй сагсан бөмбөгийн төрөлд оролцлоо. Тэмцээнд МТҮП-ын ажилтнуудаас гадна инкубаторын компаний ажилтнуудыг хамрууллаа. /100%/</p> <p>Баярын үйл ажиллагаатай холбоотой зар, мэдээллийг байгууллагын веб сайт болон холбогдох веб хуудсуудаар мэдээлэн, 5.28-нд Монголын үйлдвэрчний соёлын төв өргөөнд болсон 93 жилийн баярын хуралд бүх ажилтнууд оролцлоо. /100%/</p>
